

БАТЛАВ
ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Д.БЭХБАТ

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Худаг шинээр барихаас өмнө буюу дараа үеийн гэрэл зургийг 1 цэгээс авч, худгийн солбилцлыг нарийн тодорхойлсон байна.
2. Өрөмдлөгийн устай эсэх магадлалыг компани өөрөө хариуцна. Усны хайгуул хийж, баталгаажуулж, акт үйлдэн худаг гаргана
3. МУ-ын Хүнс хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 101,189,194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам"-ыг мөрдөнө. Үүнд:
4. Ажлын иж бүрдэлд цооног өрөмдөх, цооногийг цэвэрлэх, шавхалт туршилтын ажил хийх, ус шахуурга цахилгаанд холбох зэргийг барьж байгуулах ажлыг багтаана.
5. Худгийн усны хайгуулыг тендерт шалгарсан компани өөрийн зардлаар гүйцэтгэнэ.
6. Цооногийн гүнд тохирсон цахилгаан насос, бэхлэгээний тросстой байна.
7. Шинээр худаг өрөмдөхийн өмнө хайгуулын ажлаар устай эсэхийг тогтоосон АКТ үйлдсэн байна.
8. Худгийн цооног өрөмдлөгийн ажлын талаархи мэдээллийг өрөмдлөгийн ажлын журналд тэмдэглэнэ.
9. Цооногийг өрөмдлөгийн ажил дууссаны дараа шавхалтын ажил заавал хийж шавхалтын ажлын талаар дэлгэрэнгүй тайлан ирүүлнэ.
10. Ашиглалтын цооногийн техникийн паспортыг хөтөлж баталгаажуулан эзэмшигчид хүлээлгэн өгнө
11. Худаг уст цэгийг шинээр гаргасан далд ажлын тухай АКТ-ыг үйлдэж захиалагчид хүлээлгэн өгнө.
12. Худгийн усны шахуурга цахилгааны үүсгүүр, цахигааны утас, хянах самбар, холбох хэрэгсэл дагалдах хэрэгслийг иж бүрнээр нь худгийн цооногт суурилуулна. Тоног төхөөрөмжүүд дараах шаардлагыг хангасан байна. Гарал үүслийн гэрчилгээ, үйлдвэрлэлийн нэр хаяг, үйлдвэрлэсэн огноо, барааны олгоу улсын ISO-9001 стандарттай байх
13. Усны химийн болон бактериологийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж үр дүнг хавсаргасан байна.
14. Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS6088:2010 стандартын дагуу гүйцэтгэнэ.
15. Худгийг мотороор ажиллуулах бөгөөд тоолуур тавьсан байна.
16. Цахилгаан мотор нь худгийн гүнд тохирсон байна.
17. Талбайг цэвэрлэх /өрөмдлөгийн шлам болон барилгын ахуйн хог хаягдал гэх мэт
18. Шинэ худгийн цэг тогтоох хайгуулын ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх тухай албан ёсны гэрээ байгуулсан байх. Эсвэл өрөмдлөгийн компани өөрсдөө хийж болно.
19. Шинээр гаргасан худгийгн хүлээлгэн өгөхдөө захиалагчийн оролцоотойгоор мэргэжлийн байгууллагаар цооногийг дураңдуулж акт үйлдэн хүлээлгэн өгөх
20. Хайгуулын ажлыг хийхдээ доор дурдсан цэгүүдийн ойр орчимд хайгуул хийж цооногийг өрөмдөнө.

Даланжаргалан сумын Худаг уст цэг гаргах цэг

№	Байршил	Газрын нэр	Солбилцол		Сумын төвөөс /км/
1	Даланжаргалан сум Элдэв баг	Дэрсэн усны баруунд	46°17'39.83"N	109° 2'15.11"E	47
2	Даланжаргалан сум Элдэв баг	Сүмбэр уулын баруун урагш	46°22'51.73"N	108°58'49.92"E	54
3	Даланжаргалан сум Өнгөт баг	Хоолтоос баруун хойш	45°58'32.91"N	109°12'0.03"E	13
4	Даланжаргалан сум Өнгөт баг	Хараатын баруунд	46°23'30.59"N	109° 7'1.77"E	57
5	Даланжаргалан сум Цомог баг	Наадмын талбайн урд	45°55'36.72"N	109° 4'4.94"E	2
6	Даланжаргалан сум Цомог баг	Хар дэлийн урд	45°50'32.27"N	109° 6'39.34"E	9
7	Даланжаргалан сум Бичигт баг	Алаг хошууны хойд талд	45°38'10.44"N	108°44'47.66"E	41
8	Даланжаргалан сум Бичигт баг	Шинэ ус	45°45'40.19"N	108°37'3.58"E	43

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ, ШААРДЛАГА

Хийгдэх ажил, тоног төхөөрөмж	Үзүүлэлтүүд
Худгийн тоо	8 ширхэг
Цооногийн ашиглалтын ундарга	3 л/с-ээс багагүй
Худгийн гүн	100м-ээс багагүй
Цооног өрөмдөх /цооногийн гүн 100м хүртэл, цүүцний голч	Ф203,2мм
Суултын яндангийн голч	150 мм багагүй
Суултын яндангийн материал	Шинэ ган хоолой
Шүүр	Зохих стандартын дагуу шүүр бэлтгэнэ
Шүүрийн яндангийн материал	Зэвэрдэггүй ган, ISO9001 стандартын шаардлага хангасан үйлдвэрлэгчийн батламжийг авсан байх.
Ус өргөх хоолой	зохих голчтой Шинэ ган хоолой байна
Шүүрийн хайрган чигжээс	Шигжсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхөлгийн хэмжээ 10-15мм-ээс

	томгүй байна ижлэвтэр хэмжээтэй байна. / Голын угаасан хайрга байх/
Тунгаагуурын гүн	2м-ээс багагүй байх
Битүү угаалт хийх	Иж бүрдэл
Худгийн шавхалт хийх хугацаа	72 цагаас багагүй. үе шаттайгаар хийх
Насос	Насос-8 ширхэг, ISO9001 стандартын шаардлага хангасан. Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой, ашиглалтын ундаргад тохирсон насос, бэхэлгээний тросстой байна. Цахилгааны утас -3 салаа, худагт ашиглах шаардлага хангасан, усны хамгаалалттай, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн (залгаасгүй), ус өргөх янданд хавчиж / туузаар ороож болохгүй./ тогтоосон.
Зөөврийн цахилгаан үүсгүүр	8 ширхэг. 3400-аас дээш ватт хүчин чадалтай байх
Худгийн онгоц	Худгийн онгоц-8 ширхэг, Ан амьтан услах онгоц нь 4- 5 м-ээс багагүй урттай, 400 мм-ийн голчтой хагас цилиндр ган яндан хоолой эсвэл цутгамал төмөр бетоноор хийгдсэн байна. Ан амьтан услах онгоцны 1 талд 5-6м-ийн зайтай 1м2 хэмжээтэй бетон цутгаж ан амьтан услах талбай бүхий хонхор үүсгэж хийнэ. Ан амьтан услах онгоцны ёроол нь ус юүлэх налуутай байна.
Сантехникийн холболт	Босоо чиглэлд усны машинд ус ачих болон хэвтээ чиглэлд сувагт шахах салаалагчтай тус бүртээ бөмбөлгөн хаалттай.
Хянах самбар	380 вольт, асаах, унтраах товчлууртай, насос, ажиллаж байх болон хүчдэл байгааг гэрлээр заах индикатортой, зориулалтын тусгаарлагчтай байх.
Сургалт	Худгийн цооног өрөмдөх, ус шахуурга, цахилгаан үүсгүүр ажиллуулах үйлчилгээ хийх сургалт хийх
Худгийн паспорт	Худгийн паспортыг захиалагчид хүлээлгэн өгөх